



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 12 сарын 01 өдөр

Дугаар А/524

Арвайхээр

**Хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 194 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавирус (COVID-19) цар тахлын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор орон нутгийн зорчигч тээвэр, аймаг, сум хоорондох хувийн тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнийг түр зогсоосонтой холбогдуулан хот хоорондын авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоо, Арвайхээр сумын хэмжээнд хяналтын постод үүрэг гүйцэтгэхэд шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

2.Аймгийн Онцгой комиссын шуурхай штаб, хяналтын постод ажиллах алба хаагчдын ариутгал, халваргүйжүүлэлт, бичиг хэрэг, шатахууны зардалд зарцуулах 27,571,000 (хорин долоон сая таван зуун далан нэгэн мянга) төгрөгийг Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

3.Хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011107191

Аймгийн Засаг даргын 2020 оны 12 дүгээр сарын 01-ны өдрийн 7/524 дугаар захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ	
1	Онцгой байдлын газар	Бичгийн цаас	боодол	14	12 000	168,000
2		Принтерийн хор	ширхэг	4	65 000	260,000
3		Чингэлэг түрээс		12 сар	70000	840,000
5		мод	шуудай	28	8000	224,000
6		мод	шуудай	32	6000	192,000
7		Шатахуун /мотор, гуперлэх/	литр	1480	1400	2,072,000
8		Хяналтын байр	ширхэг	2	10000000	20,000,000
<b>НИЙТ ДҮН</b>					<b>23,564,000</b>	
1	"Онги –ус суваг" ОНӨААТҮГ	Прүс 50*50*3600	ширхэг	62	5000	310,000
2		Банз 3 см	ширхэг	26	9000	234,000
3		Хадаас 150-100 мм	кг	4	2000	8,000
4		Бүтээлэг	метр	14	2000	28,000
5		Ажлын хөлс		1	100000	200,000
6		Механизмаар ухах зардал		1	240000	480,000
<b>НИЙТ ДҮН</b>					<b>1,260,000</b>	
1	Цагдаагийн газар	Дохиур мод	ширхэг	20	9000	180,000
2		Дохиур мод	Ширхэг	32	12000	384,000
3		Дохиур модны зай	ширхэг	104	1500	156,000
4		Хантааз	Ширхэг	52	25000	1,300,000
5		Шүгэл	ширхэг	52	1500	78,000
6		Тусгаарлах хэвлэл	ширхэг	67	3000	201,000
7		Шатахуун	литр	320	1400	448,000
<b>НИЙТ ДҮН</b>					<b>2,747,000</b>	
<b>НИЙТ ДҮН</b>					<b>27,571,000</b>	